

МОНГОЛ ХЭЛНИЙ “ЭЦЭГ” ГЭДЭГ ҮГИЙН ГАРАЛ, УТГА, БҮТЦИЙН ХУВЬСАЛ

Ц.Өнөрбаян (доктор. Sc.D, профессор)

Д.Соронзон (магистр)

Авианы сэлгэц буюу дотоод нугарлын арга нь хэлний задлаг, нийлэг байгуулал үүсэхээс өмнө язгуурлаг хэв шинжтэй байх үед үг бүтээх үндсэн арга байжээ. Чухам энэ үед язгуур хорших, давтах, авиа сэлгэх, үе бүтээвэр нэмэгдэх, хасагдах, жийрэглэх арга нэн бүтээлч байв.

Хэлний хөгжлийн нэн эртний энэ үзэгдлийн ул мөр монгол хэлний язгуур үгийн бүтэц, ялангуяа анхдагч үе бүтээврийн бүтцэд уламжлагдан ирсэн байна. Бид ийм баримтыг төрөл садны нэрсийн гарал үүслийг судлахдаа ажигласан юм. Энэхүү илтгэлдээ монгол хэлний “эцэг” гэдэг үгийн гарлыг мөшгөж, ажигласан зарим зүйлээ онцлон авч үзье.

Энэ үгийн гарал, хувьслын талаар тухайлан авч үзсэн судлаачдын дотроос хамгийн анх акад. Б.Я.Владимирцов монгол бичгийн хэлний “ešige” хэмээх үгийн тэргүүн бус үеийн “i” эгшиг нь баруун халхад “etsǰg”, “etsǰg” гэж сэлгэн хэлэгддэг нь энэтхэг-европ язгуур хэлний “*peter”, санскрит хэлний “pitar” гэсэн хоёр үгийн тэргүүн үеийн эгшигтэй адил байгааг харьцуулан үзүүлжээ. (5:330)

Профессор М.Базаррагчаа: “... “a-та-гā” /атаа/ хэмээх үг нь “атаа тэнгэр” хэмээх үгийн “атаа” мөн бөгөөд энэ үгийн “a” нь “э”-тэй сэлгэж, “э-тү-гэ-н” /этүгэн/ болж, улмаар “т” нь “ч”-гээр сэлгэн, “э-чи-гэ” /эцэг/ э-чэ /эцэг/ э-чи-гэ тэ-нг-гэ-ри /эцэг тэнгэр/ хэмээх үг бүтжээ.” (2:272) хэмээн үзсэн байна.

Өвөрмонголын судлаач Г.Хайрхан, Б.Сод нар монгол хэлний төрөл садны нэрсийн утга агуулгын тухай бичсэн нэгэн өгүүлэлдээ өвөрмонголын зарим аялгуунд хэрэглэгддэг “a:~a:~” /аав/ зэрэг хэлбэрийг түрэг төрлийн зарим хэлний “ata” /эцэг/ гэсэн хэлбэртэй нэг гаралтай хэмээн үзсэн байна. (4:93-94)

Мөн судлаач С.Батхишиг алтайн хэлний хэд хэдэн төрөл садны нэрийг харьцуулсан тусгай өгүүлэлдээ монгол хэлэнд эцэг гэдэг үг *hataγa > *ataγa ~ *ätäγä ~ *etige > ešige хэмээн үүссэн гэж үзжээ. (3:75)

Монгол хэлний “эцэг” гэдэг үг нь хэлний хувьсал хөгжлийн түүхийг илэрхийлсэн нэн эртний гаралтай үг юм. Энэ үгийн анхдагч бүтэц нь “*dede” болно.

1. Монгол ба түүний төрөл хэлнүүдийн баримтаас үзвэл, эрт цагт энэ үг “*de” хэмээх үе бүтээврийн давталтаар үүссэн, эмэгтэй хүнийг илэрхийлсэн утгатай үг байсан бололтой. Учир нь эдүгээ *dede хэмээх бүтцээс үүссэн гэж үзэж болохоор төрөл хэлнүүдийн баримтуудын эр, эм хүйсийг ялган заах байдал нь төдий л тогтвортой биш байна. Үүнээс үзвэл, эрт цагт эхийн эрхт ёсны үед эх хүн буюу эмэгтэй хүнийг “эрхэм дээд хүн” гэсэн утгаар хүндлэн дээдэлдэг байснаас ийм үг үүссэн байх боломжтой юм. Уг “de” үе бүтээвэр нь “дээш” гэсэн утгатай бөгөөд эдүгээ зөвхөн монгол хэлэнд “дээр, дээвэр, дэвших-, дэгжих-, дэндэх-...” гэх мэт олон үгэнд дээшлэх чигийн утга бүрэлдүүлэн хэрэглэгдсээр байна.

2. Хэлний хөгжлийн явцад “*dede” гэсэн бүтцийн эхний “d” гийгүүлэгч нь дараа үеийнхээ гийгүүлэгчээс ондооших зэрэг шалтгаанаар сулран гээгджээ. Ингэж бий болсон “*ede” хэмээх шинэ бүтцийн “e” урагшлан хэлэгдэх болсноор өмнөх гийгүүлэгчээ

тагнайшуулж “j” болгон хувиргасан байна. Энэ үед eji [*edi<*ede] /ээж/ гэдэг үг монгол хэлэнд үүссэн бол, хувьслын нөгөө замаар хөгжсөн манж хэлэнд “e” нь “a” авиатай сэлгэснээр aja [<*adi<*ade<*ede] /ээж/ гэсэн үг үүсжээ. Үүнээс өмнө магад ээжийгээ “tete ~ mama” /мэмэ - мама/ зэрэг үгээр нэрлэж байсан байж болох юм. Жич: Манж хэлний баримтад эхийг mama ~ me /ээж/ гэнэ.

3. Нийгмийн хөгжил дараагийн шатандаа шилжин, овгийн доторх эрэгтэй гишүүдийн байр суурь өөрчлөгдөхөд, түүнийг дагаад дээрх “ede” бүтцийн утга зөвхөн эмэгтэй хүний хувьд хэрэглэгдэхээ больж, эрэгтэй хүнтэй холбогдох болсон ч хүндэлбэл зохих дээд хүн гэсэн утгаа хадгалсаар байсныг төрөл хэлний баримтууд гэрчилж байна.

Манж – түнгүс хэлнүүдэд:

Ew. edi: /эр нөхөр/; ede: ~ ode (< *ede) /анд нөхөр/;

Ev. edi /эр нөхөр, эрэгчин амьтан/;

Neg. edi: /эр нөхөр, эрэгчин амьтан/;

Oroch. edi /эрэгчин амьтан, эр нөхөр/;

Ulch. edi(n) /эр нөхөр/;

Orok. edi /эр нөхөр/; ede /анд нөхөр, эхнэр/;

Nan. eji (< *edi) /эр нөхөр/; (9:437-438)

Улмаар өмчийн сэтгэлгээ үүсэж, ангийн харьцаа бий болоход дээрх бүтцийн утга хэвээр хадгалагдаж байсан тул түүнээс “ejen” (< *eji + n < *edi + n ~ *ede + n) /эзэн/ гэдэг үг ч үүссэн байна.

Sol. edi: ~ eji: /эзэн/;

Neg. ejen /эзэн/;

Oroch. eje(n) /эзэн/;

Ud. eje(n) /захирагч/;

Ulch. eje(n) /эзэн/;

Orok. ede(n) /эзэн, хаан/;

Nan. eje: /эзэн, хаан/;

Хэрэв монгол хэлний d – г түрэг хэлний y – тэй тохирно гэж үзвэл, орчин үеийн зарим түрэг хэлний баримтууд эдүгээ мөн дээрх бүтэц, утгыг хадгалсаар байгаа ажээ. Өөрөөр хэлбэл, “эзэн” гэсэн үгийг тэмдэглэсэн дараах хэлбэрүүд байна. Үүнд: eye (Trkm.), iyä (Baš, Tat.), iye (Kaz.) гэсэн жишээнүүдийг дурдаж болно. (11:734-735)

Профессор Г.И.Рамстедт дээрх эзэн гэдэг үгийн монгол, манж, түрэг, солонгос хэлний зохих хэлбэрүүдийг харьцуулсан өгүүлэл бичжээ. (12:69-70)

4. “ede” бүтэц нь хойшид *ete > *ate > ata гэсэн дарааллаар хувьссаны дүнд чуваш хэлэнд atte [<*ate] > ati [<*ati<*ate] /эцэг/ (10:70), эртний түрэг хэлэнд ata /эцэг/ (6:65) гэсэн бие даасан үг болж тогтсоныг мэдэж болно. Харин орчин үеийн түрэг хэлнүүдэд энэ үг дараах байдалтай тохиолдоно. Үүнд: ata (Az. Baš. Kaz. Kir. Uz. Tat. Uig.); äti (Tat.); atay (Baš.) гэх мэт. (11:43-44)


5. Монгол хэлний хувьд *ede > *ete > *eti > *etike [<*eti+ke] > ešige (Mo.) гэж төрөл садны нэр бүтээдэг “хүн” гэсэн утгатай “ke” /ke~ge~qa~ya/ үе бүтээврийг дагуулснаар “эрхэм дээд хүн” хэмээх утгыг илтгэсэн тусгай үг болж үлджээ.

6. Харин манж-түнгүс хэлнүүдэд *ede бүтэц нь дангаараа болон зохих бүтээврүүдийг өөртөө нэгтгэсний дүнд бүтэц, утгын нэлээд хувьсалд орсон бөгөөд түүнд чухам “эцэг” гэсэн утга үлдээгүй боловч ерөнхийдөө эцэгтэй холбоо бүхий хэдэн үгэнд хэвшин тогтсон байна. Тэдгээрийг дор үзүүлэв. Үүнд:

- “авга ах” Ma. esxen, еѿке; Nan. ekse: [*<esken], еѿе, еѿеке; Ev. ete:~āta;
- “өвөг эцэг” Neg. etixen~etuxen; Sol. etikke:~etxe:; Ev. etiken~etike:n~ettuke:n~(9:469)
- “хадам эцэг” Neg. etixen~etuxen; Ev. etke:~āt'ka гэх мэт.

Иймд манж-түнгүс хэлнүүдэд “аав” гэсэн үг нь “эцэг” гэсэн утгыг давхар илтгэн хэрэглэгдэх болжээ.

Дээр өгүүлсэн бүхнийг хураангуйлан дараах байдлаар үзүүлэв.



0. ***dede** ~ dedä [<*dede] /эртний түрэг хэл/; dada [<*dede] /Уйгур хэл/; (cf. Ma. jeje /эцэг/)

1. ***ede**

1.1. ***ede**

1.1.1. **ede**

1.1.1.1. ede – “эхнэр” /солон, эвенк, ороки/ (9:437-438)

– “анд нөхөр” /эвенк, ороки/ (9:437-438)

1.1.1.2. edi~edi: – “эр нөхөр” /эвенк, эвен, орочи, ороки, нанай, ульча, негидаль/ (9:437-438)

– “эрэгчин” /орочи, эвен, негидаль/ (9:437-438)

1.1.2. **edi**

1.1.2.1. edi – (1.1.1.2-ийг үз.)

1.1.2.2. eji – “ээж” /Монгол бичгийн хэл/

– “эр нөхөр” /Нанай/ (9:437-438)

1.2. ***ade**

1.2.1. ***ade**

1.2.1.1. *ade > aje: “аав” /Cha./ (4:93)

- аја “эцэг” /SY./ (4:94)
- аја: [<*ada] “аав” /Khor, Cha./ (4:93)

1.2.1.2. ada > ad'a: “аав” /Oir./ (4:93)

1.2.2. *adi

1.2.2.1. *adi

1.2.2.2. аји – Монголын зарим нутгийн аялгуунд эх ба төрөл садны ахмад настай эмэгтэйчүүдийг а:ји:, аја:, а:ја: гэж дуудна. (4:93) (cf. аја “ээж” /манж/)

2. *ete

2.1. *ete

2.1.1. *ete

2.1.1.1. *ete

2.1.1.2. *eti > *eti + ke > есіке ~ есіге “эцэг” /монгол бичгийн хэл/

2.1.2. *eti

2.1.2.1. *eti

2.1.2.2. есі – “ах” /эртний түрэг хэл/ (6:162), есә “эгч” /эртний түрэг хэл/ (6:167)

2.2. *ate

2.2.1. *ate

2.2.1.1. *ate > atte “эцэг” /чуваш хэл/ (10:70)

2.2.1.2. ата – “эцэг” /эртний ба орчин үеийн олон түрэг хэл/
– “эмгэн” /солон, эвенк хэл/ (9:437-438)

2.2.2. *ati

2.2.2.1. *ati > ati, äti “эцэг” /чуваш хэл/ (10:70)

2.2.2.2. асі – “эцэг” /солон хэл/ (9:437-438)

– аса “эцэг” /Dag./ (4:94)

– “ахмад настай эмэгтэй” (6:4), аси~ају “эцэг” /эртний түрэг хэл/ (6:6,74)

Энэхүү тогтолцоонд хамаарагдаагүй буюу цаашид нарийвчлан задарсан хэсгүүдэд дурдагдах ёстой бусад олон хэлбэрийг алтайн язгуурын хэлнүүдийн төрөл садны нэрсийн баримтаас өдий төдийгөөр нь олж болохыг энд дурдах хэрэгтэй юм.

Дүгнэлт

Анхны хүй нэгдлийн үе буюу эхийн эрхт ёсны үед хүмүүс эмэгтэй хүнийг хүндэтгэх, шүтэх зэргээр маш их хүндтэй байр сууринд тавьдаг байсны ул мөр нь эдүгээ монгол ба түүний төрөл хэлнүүдийн төрөл садны нэрсэд дээрх байдлаар хадгалагдан үлджээ. Нөгөө талаар энэ нь өгүүлж буй тэр цагт эдгээр хэлтнүүдийн хэлний ялгаа төдийлөн ихээр гараагүй байсныг харуулах зохих нэгэн баримт болж болох юм.

Алтайн хэлнүүдийн “эцэг” гэдэг үгийн гарлыг тайлбарлахад, дэлхийн олон хэлний “эцэг” (аав) ба “эх” (ээж)/ гэдэг үгийн ерөнхий хэлбэртэй тохирч байгааг угтаа хүүхдийн хэлд орох нийтлэгтэй холбож үзэх нь зүйтэй юм. Иймээс ч түрэг хэлний ата /эцэг/ гэсэн үгийн гарлыг судалсан М.Ресянен зэрэг судлаачид түүнийг хүүхдийн хэл ярианы шулганаантай холбон тайлбарласан байна. (7:201)

Төрөл хэл, аялгуунуудын товчилсон нэрсийн жагсаалт

/түрэг хэлний бүлэг/

- АТ. Эртний түрэг хэл
- Az. Азербайжан хэл
- Ваś. Башкир хэл

Kaz. Казак хэл
Kir. Киргиз хэл
Tat. Татар хэл
Trkm. Туркмен хэл
Uig. Уйгур хэл
Uz. Өзбек хэл

/манж-түнгүс хэлний бүлэг/

Ev. Эвен хэл
Ew. Эвенк хэл
Ma. Манж хэл
Nan. Нанай хэл
Neg. Негидаль хэл
Oroch. Орочи хэл
Orok. Ороки хэл
Sol. Солон хэл
Ud. Удэй хэл
Ulc. Ульча хэл

/монгол хэл, аялгуу/

Cha. Цахар аялгуу
Dag. Дагур хэл
Khor. Хорчин аялгуу
Oir. Ойрд аялгуу
SY. Шар-Уйгур хэл

Ном зүй

1. Бадамдорж, Д., Монгол хэлний утга судлал, Утга ялгагч авиалбар, бүтээврийн утга, Тэргүүн дэвтэр, Уб., 2001
2. Базаррагчаа, М., Монгол үгийн гарлыг мөшигх нь, Уб., 1994
3. Батхишиг, С., Монгол, түрэг, манж хэлний ураг төрлийн зарим нэрийн тухай, - МУИС. 21(2003)
4. Хайрхан, Г., Сод, Б., Монгол хэлний зарим төрлийн харьцааны нэрийн шинжилгээ, - ӨМНШУ. 1(1993)
5. Владимирцов, Б. Я., Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., 1929, 436 с
6. Древнетюркский словарь, Л., 1969
7. Севортян, Э. В., Этимологический словарь тюркских языков, Общетюркские и межтюркские лексические основы на гласные, М., 1974
8. Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков, том I, Л., 1975
9. Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков, том II, Л., 1975
10. Федотов, М. Р., Этимологический словарь чувашского языка, I, Чебоксары, 1996
11. Karsilastirmali türk lehzeleri sözlüğü, I, Ankara, 1991
12. Ramstedt, G. J., Alte turkische und mongolische Titel, 1939, 59-82
13. Sun Zhu., Menggu yu yan cidian, Qinghai, 1990

Resume

In any languages, particular words which describe relatives are reflected on the ancient features of a language development. As an example we attempt to define the origin of the Mongolian word “father” in this paper. To do so we compared some relevant facts in the Mongolian language and its distant relative languages such as Turkish and Manchu-Tungus and we have come to the conclusion that the word was originated in this way; *de + *de > *dede > *ede > *ete > *eti > *etike [<*eti+ke] > ečige (Mo.).